

БАГШЛАХ УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ УДИРДАМЖ.

Багшлах ур чадварын үнэлгээний зорилго нь багшлахуйн ур чадвар болон багшийн хувь хүний хөгжлийг дэмжих явдал юм. Энэхүү баримт бичиг нь их сургуулийн профессорын болон багшийн замналын тогтолцоонд зориулан багшийн ур чадварын үнэлгээ хийх үндсэн загвар юм. Горилогчийн ерөнхий багшлах ур чадвар, төлөвшил, сурган заах арга зүйн чадавхыг тодорхойлоход энэхүү иж бүрэн үнэлгээний аргыг ашигладаг.

Тайлбар

1. Багшлах ур чадварын үнэлгээ нь цогц үнэлгээ бөгөөд энэ нь баримт бичигт тусгагдсан багшлах ур чадварын бүрэлдэхүүн хэсгүүд болон бусад салбарын ололт амжилт зэргийг олон талаас харгалзан үздэг.
2. Багшлахуйн ур чадварын үнэлгээний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь:
 1. Багшлахуй, суралцахуйн арга, арга зүй
 2. Багшийн туршлага
 3. Сургалтын хөтөлбөр хөгжүүлэлт, боловсролын манлайлал
 4. Багшийн хөгжил
 5. Санал хүсэлт
 6. Багшлах чадвар
3. 2-4-р хуудсанд багшлахуйн чадамжийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг янз бүрийн туршлага дээр тулгуурлан түвшин бүрээр жишээ болгон тайлбарласан болно. Гэхдээ эдгээр нь яг таг нарийн шаардлага биш бөгөөд ур чадварыг өөрөөр тодорхойлж болно гэдгийг анхаарна уу. Сургуулиуд тухайн өөрийн салбарт хамааралтай нэмэлт тодруулга хийж болно.
4. Багшлах ур чадварын бүрэлдэхүүн хэсэг бүрийг горилогчийн албан тушаалын шатлал (дэд профессор эсвэл профессор) болон тухайн салбарыг харгалзан үнэлнэ. Нэмж дурдахад, ялангуяа дэд профессорын түвшинд ирээдүйн боломжуудыг илүү анхаарч үзэх хэрэгтэй.
5. Багшлах ур чадварын үнэлгээг 1) горилогчийн портфолио, 2) нээлттэй хичээл [тушаал дэвшиж буй тохиолдолд, жинхэнэ хичээлийн явцад] болон 3) горилогчтой хийсэн ярилцлагад үндэслэнэ.

Багшийн портфолио хэрхэн бүрдүүлэх талаар Нэр дэвшигчдэд зориулсан удирдамж -аас үзнэ үү.
6. Бүрэлдэхүүн хэсэг бүрийг сайтар судалсны дараа үнэлгээний хороо горилогчийн **багшлах ур чадварын ерөнхий үнэлгээг өгдөг**. Ерөнхий цогц үнэлгээ нь горилогчийн цаашдын хөгжлийн чиглэлийг мөн зааж өгдөг.

Үнэлгээний хэмжээс нь: Шинэхэн, Ахиж буй, сайн, өндөр чанартай, маш сайн (Хэрэв багшлахуйн ур чадварыг нотлох баримт байхгүй эсвэл хомс бол хүлээн зөвшөөрөхгүй гэсэн үнэлгээг өгч болно).

ХЭМЖЭ ЭС БҮРЭЛДЭХҮҮН	ШИНЭХЭН	АХИЖ БҮЙ	САЙН	ӨНДӨР ЧАНАР	МАШ САЙН
1. 1. Багшлахуй, суралцахуйн арга, арга зүй <i>Нэр дэвшигчийн багшлахуй, суралцахуйн тухай үзэл баримтлал, багшилсан практик туршлага, цаашлаад тухайн багшийн арга барил нь их сургуулийн боловсролын стратеги, үнэт зүйлс, стратегийн зорилтууд хэрхэн нийцэж байгаа байдал.</i>	Нотлох баримт олдоогүй эсвэл хязгаарлагдмал.	Багшлахуй, суралцахуйн зарчмуудын талаар тодорхой ойлголттой, тэдгээрийн талаар нухацтай эргэцүүлдэг	Багшлахуй, суралцахуйн арга барилын талаар сайн мэдлэгтэй, өөрийнх нь багшлахуйд нөлөө үзүүлдэг. Сургалтын арга барил нь их сургуулийн боловсролын/ сургалтын стратеги, үнэт зүйл, стратегийн зорилтод хэсэгчлэн нийцсэн	Багшлахуй, суралцахуйн арга барилын талаар өндөр мэдлэгтэй, өөрийнх нь багшлахуйд нөлөө үзүүлдэг. Багшлахуй, суралцахуй, оюутан удирдах үйл ажиллагааны талаар өөрийн үзэлтэй, энэ оюутны сурах үйл ажиллагааг дэмжиж байгаа үндэслэл нотолгоотой. Сургалтын арга барил нь их сургуулийн боловсролын/ сургалтын стратеги, үнэт зүйл, стратегийн зорилтод системтэй нийцсэн	Багшлахуй, суралцахуйн өөрийн гэсэн арга зүйг бий болгосон, тухайн арга барилыг сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа тодорхой нотолгоо. Энэхүү арга барил нь оюутны суралцахуйн үр дүнд эергээр нөлөөлж буй нь нотлогдсон. Багшлахуй, суралцахуй, оюутан удирдах үйл ажиллагааны талаар үндэслэлтэй үзэл баримтлалтай, энэ оюутны сурах үйл ажиллагааг дэмжиж байгаа үндэслэл нотолгоотой. Сургалтын арга барил нь их сургуулийн боловсролын/ сургалтын стратеги, үнэт зүйл, стратегийн зорилтод системтэй нийцсэн

2. БАГШИЙН ТУРШЛАГА <i>Үүнд их сургуулийн бакалавр, магистр, докторын сургалт түүнчлэн насан туршийн боловсролын хөтөлбөрт сургалт явуулсан туршлага багтана. Мөн хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, эсвэл онлайн сургалтыг дэмжих зэрэг орно.</i>	Нотлох баримт олдоогүй эсвэл хязгаарлагдмал.	Багшлахуйн тодорхой туршлага хуримтлуулсан ба сургах, чиглүүлэх эсвэл сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах чадвартайгаа харуулсан	Нэг болон түүнээс дээш хичээл зааж байсан туршлагатай, хариуцсан багш, эрдэм шинжилгээний зөвлөхийн үүрэг эсвэл үүнтэй төстэй үүрэг хамаарна. Нэг болон түүнээс олон оюутан удирдсан, ихэвчлэн бакалаврын болон магистрын түвшний дипломын ажил, төсөл эсвэл ижил түвшний ажлууд хамаарна (дууссан ба/эсвэл үргэлжилж байгаа) Хичээлийн хөтөлбөр хөгжүүлсэн тодорхой туршлагатай. Багшлахуй, суралцахуйн хэрэглэгдэхүүн, материал эсвэл онлайн хичээл хөгжүүлсэн зарим нотолгоо.	Багшийн туршлага нь ердийн багшийн үүрэг хариуцлагын хүрээнд гол төлөв бакалавр, магистрын түвшний сургалтад чиглэсэн(жишээ нь: зөвлөх багш, эрдэм шинжилгээний зөвлөх, эсвэл үүнтэй төстэй). Бүх түвшинд оюутан удирдан чиглүүлэх, зөвлөсөн туршлагатай (дууссан ба/эсвэл үргэлжилж байгаа). Хичээлийг системтэй хөгжүүлсэн тодорхой нотолгоотой. Сургалтын хэрэглэгдэхүүн, материал хөгжүүлсэн тодорхой нотолгоотой.	Өргөн цар хүрээтэй багшилсан туршлага: янз бүрийн түвшний болон өөр өөр зорилтот бүлгүүдэд зориулсан олон хичээл орсон (жишээлбэл, бакалавр, магистр, доктор, насан туршийн/гүйцэтгэх ажилтан), олон төрлийн сургалтын хэлбэр (жишээ нь, хамтран заах, танхимын сургалт, онлайн сургалт) . Бүх түвшинд оюутан удирдан чиглүүлэх, зөвлөсөн туршлагатай (дууссан ба/эсвэл үргэлжилж байгаа). Хичээлийг системтэйгээр шинэлэг байдлаар амжилттай хөгжүүлсэн олон тооны нотолгоотой. Сурган заах арга зүйн болон технологийн шинэ боломжуудын ашиглан сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлсэн өргөн хүрээний нотолгоотой. Тэдгээр нь бусад багшийн өөр хичээлүүдэд, ашигладаг .
--	---	---	--	--	--

хэмжээ с Бүрэлдэхүүн	ШИНЭХЭН	АХИЖ БУЙ	САЙН	ӨНДӨР ЧАНАР	МАШ САЙН
3.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ХӨГЖҮҮЛЭЛТ, БОЛОВСРОЛЫН МАНЛАЙЛАЛ энэ нь хичээлийн хөтөлбөр хөгжүүлэх, хичээл заах үйлээс давсан боловсролын үйл, үүрэг хариуцлагыг хамаарна.	Нотлох баримт олдоогүй эсвэл хязгаарлагдмал.	Мэргэжил/хөтөлбөр хөгжүүлэлт эсвэл тэнхим салбарын хэмжээнд боловсролын удирдлагын үйл ажиллагаанд оролцох боломжтойг харуулсан. Хичээл/мэргэжил/хөтөлбөрийн түвшинд сургалтын хөтөлбөр боловсруулах болон боловсролын манлайлалд оролцох боломжтойг харуулах.	Мэргэжил/хөтөлбөр хөгжүүлэлт эсвэл тэнхим салбарын хэмжээнд боловсролын удирдлагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцож байсан туршлага, нотолгоотой . Сургуулийн түвшинд багшийн хөгжил, менежментийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцдог.	Мэргэжил/хөтөлбөр хөгжүүлэлт эсвэл тэнхим салбарын хэмжээнд боловсролын удирдлагын үйл ажиллагаанд идэвхтэй, үүрэгтэй оролцож байсан туршлага, нотолгоотой . Сургуулийн түвшинд багшийн хөгжил, менежментийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог.	Мэргэжил/хөтөлбөр хөгжүүлэлт эсвэл тэнхим салбар, сургуулийн хэмжээнд боловсролын удирдлага, менежментийн үйл ажиллагаанд өндөр үүрэгтэй оролцож байсан арвин туршлага, нотолгоотой . Тухайн салбарт (жишээ нь сургууль, их сургууль, үндэсний эсвэл олон улсын түвшний боловсролын манлайлал эсвэл хөгжил) оруулсан хувь нэмэр, нөлөөллийн илүү өргөн хүрээний нотолгоо. Залуу багш нарт сурган хүмүүжүүлэх, сурган заах арга зүйн чиглэлээр зөвлөн тусалдаг нотлох баримт.
4.БАГШИЙН ХӨГЖИЛ <i>сурган хүмүүжүүлэх ухаанд суралцсан байдал эсвэл өөрийн багшлахуйн чадварыг хөгжүүлсэн бусад аргууд, түүнчлэн эдгээрийн нотлох баримт зэргийг багтаана. Энэ бүрэлдэхүүн хэсэгт сургуулиуд өөрсдийн онцлог бүхий шаардлагыг тодорхойлж болно.</i>	Нотлох баримт олдоогүй эсвэл хязгаарлагдмал.	Сурган хүмүүжүүлэх ухаан, сурган заах арга зүй чиглэлээр олон хичээл үзэж судалсан эсвэл албан бус хэлбэрээр багшлахуйн үр чадвар эзэмшсэн байж болно. Багш болж хөгжих боломжтой, эсвэл багшийн замналаар хөгжиж буй зарим нотолгоо.	Сурган хүмүүжүүлэх чиглэлээр дор хаяж 5 ECTS хичээл судалсан, эсвэл багшлахуй, суралцахуйн талаарх мэдлэгийг өөр аргаар эзэмшсэн баталгаа нотолгоо. Багшийн хувьд хөгжиж байгаагийн сайн нотолгоотой. Жишээлбэл өөрийн давуу тал, хөгжүүлэх чиглэлээ тодорхойлсон.	Сурган хүмүүжүүлэх чиглэлээр 5 ECTS эсвэл түүнээс дээш кредитийн хичээл үзэж судалсан, эсвэл багшлахуй, суралцахуйн талаарх мэдлэгийг өөр аргаар эзэмшсэн баталгаа нотолгоо. Багшийн хувьд хөгжиж байгаагийн тодорхой нотолгоотой. Жишээлбэл өөрийн давуу тал, хөгжүүлэх чиглэлээ тодорхойлсон. Сургалтын судалгаа нь хэрхэн сурган заах арга зүйг хөгжүүлдэг талаар ойлголтоотой.	Сурган хүмүүжүүлэх чиглэлээр 5 ECTS эсвэл түүнээс дээш кредитийн хичээл үзэж судалсан, эсвэл багшлахуй, суралцахуйн талаарх мэдлэгийг өөр аргаар эзэмшсэн баталгаа нотолгоо. Багшийн хувьд хөгжиж байгаагийн олон тооны нотолгоотой. (жишээ нь багшийн хувьд өөрийн давуу тал, хөгжлийн талбараа системтэйгээр олон чиглэлээр тодорхойлсон; Сургалтын судалгаа нь хэрхэн сурган заах арга зүйг хөгжүүлдэг талаар ойлголтоотой). Сурган заах арга зүйн хөгжилд хувь нэмэр оруулдаг (тухайлбал, тухайн чиглэлээр сургалтын судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэл).

хэмжээ с БҮРЭЛДЭХҮҮН	ШИНЭХЭН	АХИЖ БУЙ	САЙН	ӨНДӨР ЧАНАР	МАШ САЙН
5.САНАЛ ХҮСЭЛТ <i>Сургалт, хичээлийн хүрээнд оюутнуудаас ирсэн санал хүсэлтүүдийг харгалзан үздэг нотолгоо, түүнчлэн нэр дэвшигч нь сургалтыг сайжруулахын тулд тухайн санал хүсэлтийг хэрхэн ашигласан зэрэг багтана. Мөн хамт олны санал хүсэлт, багшлахуйн ур чадварын бусад үнэлгээ, өргөмжлөл, шагнал зэргийг багтааж болно.</i>	Нотлох баримт олдоогүй эсвэл хязгаарлагдмал.	Зарим санал хүсэлтийг цуглуулсан. Цуглуулсан санал хүсэлтийн заримыг эсвэл цөөхнийг ашигласан	Зарим санал хүсэлтийг цуглуулсан бөгөөд ихэвчлэн бүтээлч санал хүсэлт байдаг Цуглуулсан санал хүсэлтийг ашиглах хүчин чармайлт гаргасан нотолгоо.	Санал хүсэлтийг системтэй, зохих ёсоор цуглуулж, дүн шинжилгээ хийж, ашигладаг. Олон төрлийн санал хүсэлтийн жишээг дэлгэн харуулсан Цуглуулсан санал хүсэлт нь ихэвчлэн бүтээлч, эерэг хандлагатай байдаг. Санал хүсэлтийг ашиглах идэвхтэй хүчин чармайлтын талаар нотолгоо (жишээ нь, сургалтын хөгжилд, санал хүсэлтийг эергээр ашигласан гэх мэт). Сайн багш гэж олонд танигдсан хүртсэн	Санал хүсэлтийг системтэй, оновчтой, иж бүрэн цуглуулж, дүн шинжилгээ хийж, ашигладаг. Олон төрлийн санал хүсэлтийн жишээг дэлгэн харуулсан Цуглуулсан санал хүсэлт нь ихээхэн бүтээлч, эерэг байдаг. Санал хүсэлтийг хөгжлийн гол хэрэгсэл болгон ашигладаг (жишээлбэл, санал хүсэлтийг өөрийн мэргэжлийн өсөлт хөгжлийг дэвшлүүлэхэд системтэйгээр ашигладаг). Сайн багшийн өргөмжлөл, шагнал.
6. Багшлах чадвар			Нээлттэй хичээлээр үнэлэгдэнэ (тушаал дэвшиж байгаа тохиолдолд хичээл зааж байх үеэр үнэлгээг явуулах нь илүү)		